

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОЙН АНГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын код: ХОА-2021/114/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2021 он

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд

тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: Х

khovd@audit.gov.mn

Аудитын менежер:

Утас: 70432545 Цахим хаяг:

Тунгалаг бүртгэл Аудит ХХК

Аудитор: Ч.Мөнхцооз

Утас: 99028555

Цахим хаяг: munhuu8555@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|-------------------------------------------------------------|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |

Агуулга

| | |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| 1.Төрийн аудитын санал, дүгнэлт | 3 |
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан..... | 5 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 5 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 5 |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 7 |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 8 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 8 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан | 9 |
| 3. Аудитын тайлан..... | 9 |
| 3.1. Ерөнхий зүйл..... | 10 |
| 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй..... | 10 |
| 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт | 10 |
| 3.4. Материаллаг байдал | 11 |
| 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд | 11 |
| 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт | 12 |
| 3.7. Шилэн дансны мэдээлэл | 13 |
| 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 13 |
| 3.9. Аудитын илрүүлэлт..... | 13 |
| Залруулсан алдаа..... | 13 |
| Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил | 13 |
| Аудитын зөвлөмж..... | 14 |
| 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд | 14 |
| 4. Менежментийн захидал..... | 14 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт | 14 |

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цацбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН
ДАРГА Ц.ДАВААХҮҮ ТАНАА

2021.08.25 № 2/143
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Сум дундын ойн ангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сум дундын ойн ангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга тогилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, Ойн тухай хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх, ойн санг хамгаалах ажлыг удирдан зохион байгуулах, ойн хортон, түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, ойн мэдээллийн санг бүрдүүлэх, ойн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх мод бут тарих, арчилж ургуулах талаар сургалт сурталчилгаа зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

02102040S

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|-----------------------------------------------------------------------|----------------------|----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 8,107,406.59 | 7,682,764.00 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 00.00 | 17,000.00 |
| 31110 | Төгрөг | 00.00 | 17,000.00 |
| 31130 | Нэмэлт санхүүжилт | 00.00 | 17,000.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 00.00 | 00.00 |
| 3121 | Төгрөг | 00.00 | 00.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 00.00 |
| 33 | АВЛАГА | 1,895,986.59 | 1,895,335.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 651.59 | 00.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 1,895,335.00 | 1,895,335.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 6,211,420.00 | 5,787,420.00 |
| 354 | Хангамжийн материал | 1,847,320.00 | 1,847,320.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,847,320.00 | 1,847,320.00 |
| 35500 | Биологийн хөрөнгө | 4,364,100.00 | 3,940,100.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 46,234,200.89 | 35,767,711.15 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 46,234,200.89 | 35,767,711.15 |
| 392 | Биет хөрөнгө | 45,794,200.81 | 35,492,711.04 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,927,800.00 | 1,927,800.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -321,300.00 | -642,600.00 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 64,130,520.00 | 64,130,520.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -30,943,181.97 | -38,380,520.04 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 39,163,323.25 | 39,163,323.25 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -28,477,128.67 | -30,889,980.41 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,300,000.00 | 1,300,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -985,831.80 | -1,115,831.76 |
| 393 | Биет бус хөрөнгө | 440,000.08 | 275,000.11 |
| 39301 | Програм хангамж | 880,000.00 | 880,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -439,999.92 | -604,999.89 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 54,341,607.48 | 43,467,466.15 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 00.00 | 1,542.51 |
| 412 | Богино хугацаат зээлийн өглөг | 00.00 | 1,542.51 |
| 4136 | Бусад өглөг | 00.00 | 1,542.51 |
| 41363 | Татварын өглөг /ТӨҮГ/ | 00.00 | 1,542.51 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 54,341,607.48 | 43,448,932.64 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 54,341,607.48 | 43,465,923.64 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 150,000.00 | 150,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 150,000.00 | 150,000.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 54,191,607.48 | 43,315,923.64 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 54,191,607.48 | 54,191,607.48 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -10,875,683.84 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 54,341,607.48 | 43,467,466.15 |

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|----------------------------------------|----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 83,323,740.80 | 56,398,138.00 |

Ойн ангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|------------------------------------------------------------------------------|----------------------|-----------------------|
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 36,503,740.80 | 1,491,428.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 36,503,740.80 | 1,491,428.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 36,503,740.80 | 1,491,428.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,222,790.00 | 1,491,428.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 33,280,950.80 | 01.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 46,820,000.00 | 54,906,710.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 00.00 | 1,820,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 1,820,200.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 46,820,000.00 | 53,086,510.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 46,820,000.00 | 53,086,510.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 62,041,737.91 | 67,273,821.84 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 62,041,737.91 | 67,272,869.63 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 61,360,947.91 | 67,272,869.63 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 34,577,111.41 | 41,699,727.89 |
| 210101 | Үндсэн цалин | 26,281,676.41 | 31,906,716.21 |
| 210102 | Нэмэгдэл | 6,562,935.00 | 8,067,504.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,732,500.00 | 1,725,507.68 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 3,995,400.00 | 5,405,284.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,716,800.00 | 3,859,421.74 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 319,600.00 | 382,261.36 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 255,800.00 | 310,300.40 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 63,900.00 | 77,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 639,300.00 | 775,700.50 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,458,611.00 | 6,432,190.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 400,740.00 | 291,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,567,865.00 | 3,136,950.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 418,000.00 | 347,440.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,072,006.00 | 2,656,200.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 402,600.00 | 92,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 402,600.00 | 92,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 732,000.00 | 376,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 732,000.00 | 376,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,063,200.00 | 1,449,678.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,934,800.00 | 846,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 262,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,000.00 | 184,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 95,400.00 | 121,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 30,000.00 | 35,178.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,132,025.50 | 11,117,489.74 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 651000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 10,132,025.50 | 10,466,489.74 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 680,790.00 | 700,952.21 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 585,000.00 | 700,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 585,000.00 | 700,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 95,790.00 | 952.21 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 95,790.00 | 952.21 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 21,282,002.89 | -10,875,683.84 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 21,282,002.89 | -10,875,683.84 |

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|------------------------------------------------------------------------------|----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 45,726,790.00 | 56,398,138.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 3,222,790.00 | 1,491,428.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 3,222,790.00 | 1,491,428.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,222,790.00 | 1,491,428.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,222,790.00 | 1,491,428.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 42,504,000.00 | 54,906,710.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 00.00 | 1,820,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 1,820,200.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 42,504,000.00 | 53,086,510.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 42,504,000.00 | 53,086,510.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 50,042,790.00 | 56,398,138.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 50,042,790.00 | 56,398,138.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 49,362,000.00 | 56,398,138.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 31,929,935.00 | 37,610,002.68 |
| 210101 | Үндсэн цалин | 23,634,500.00 | 27,816,991.00 |
| 210102 | Нэмэгдэл | 6,562,935.00 | 8,067,504.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,732,500.00 | 1,725,507.68 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 3,995,400.00 | 4,827,106.11 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,716,800.00 | 3,281,245.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 319,600.00 | 382,261.11 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 255,800.00 | 310,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 63,900.00 | 77,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 639,300.00 | 775,700.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,009,515.00 | 5,787,190.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 302,900.00 | 291,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,567,865.00 | 3,786,950.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 418,000.00 | 336,660.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 720,750.00 | 2,048,700.00 |
| 2105 | Нормативт зардал | 371,250.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 371,250.00 | 00.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 695,500.00 | 92,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 695,500.00 | 92,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 732,000.00 | 376,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 732,000.00 | 376,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,628,400.00 | 5,910,887.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,500,000.00 | 5,307,709.00 |

| | | | |
|-------------|-----------------------------------------------------------------------------|-------------------|-------------------|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 262,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,000.00 | 179,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 95,400.00 | 121,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 30,000.00 | 40,178.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 943,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 943,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 680,790.00 | 850,952.21 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 585,000.00 | 850,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 585,000.00 | 850,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 95,790.00 | 952.21 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 95,790.00 | 952.21 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | |

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|-------|----------------------------------------|
| C08 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 150,000.00 | 00.00 | 54,191,607.48 | 00.00 | 54,341,607.48 |
| D01 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 150,000.00 | 00.00 | 54,191,607.48 | 00.00 | 54,341,607.48 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 150,000.00 | 00.00 | 54,191,607.48 | 00.00 | 54,341,607.48 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -10,875,683.84 | 00.00 | -10,875,683.84 |
| D09 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 150,000.00 | 00.00 | 43,315,923.64 | 00.00 | 43,465,923.64 |

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|-------------------------------------------------------|-----------------------|---------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 59,916,500.00 | 54,576,985.79 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 59,916,500.00 | 54,576,985.79 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 59,316,500.00 | 53,726,985.79 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 35,736,400.00 | 41,698,192.00 |
| 210101 | Үндсэн цалин | 26,574,100.00 | 35,865,305.00 |
| 210102 | Нэмэгдэл | 7,429,800.00 | 4,201,887.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,732,500.00 | 1,631,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 4,824,300.00 | 5,629,122.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,395,000.00 | 3,961,377.25 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 357,400.00 | 417,023.93 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 285,800.00 | 333,479.12 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 71,500.00 | 83,428.12 |

| | | | |
|---------------|----------------------------------------------------------------------|---------------|---------------|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 714,600.00 | 833,814.49 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7,343,000.00 | 4,732,710.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 324,800.00 | 291,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,963,900.00 | 3,786,950.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 717,700.00 | 336,660.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 336,600.00 | 317,500.00 |
| 2105 | Нормативт зардал | 400,000.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 400,000.00 | 00.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 700,000.00 | 92,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 700,000.00 | 92,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,425,000.00 | 376,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,425,000.00 | 376,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,887,800.00 | 576,678.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,500,000.00 | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 120,000.00 | 262,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 140,000.00 | 179,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 97,800.00 | 95,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 30,000.00 | 40,178.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1000000.00 | 621782.89 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,000,000.00 | 621,782.89 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 600000.00 | 850000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 600,000.00 | 850,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 600,000.00 | 850,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 59,916,500.00 | 54,577,938.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 55,916,500.00 | 53,086,510.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 55,916,500.00 | 53,086,510.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 4,000,000.00 | 1,491,428.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,000,000.00 | 1,491,428.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 03.00 | 03.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 02.00 | 02.00 |

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|-------------|------------------------------------------------------------------------------|---------------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,820,200.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,820,200.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,820,200.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,820,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,820,200.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1820200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,820,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,820,200.00 |

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Ойн ангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн захирагч Ц.Даваахүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд бараа материалын тайлан гаргалт, эд хариуцагчийн тооцоо бодолт, баталгаажуулалт, анхан шатны баримт бүрдүүлэлтийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 3 дугаар сарын 8-наас 2021 оны 03 дугаар сарын 13-ны хооронд Тунгалаг бүртгэл аудит ХХК-ны ахлах аудитор Ч. Мөнхцооз аудитор Ч.Эрдэнэчимэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Тус байгууллага нь Ойн тухай хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх, ойн санг хамгаалах ажлыг удирдан зохион байгуулах, ойн хортон, түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, ойн мэдээллийн санг бүрдүүлэх, ойн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх мод бут тарих арчилж ургуулах талаар сургалт сурталчилгаа зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, ойжуулалтын ажлыг гүйцэтгэх, ой хамгаалах иргэдийн нөхөрлөлийн ажилд дэмжлэг үзүүлэх гэж үндсэн зорилго тодорхойлжээ.

Дээрхи зорилгоо хэрэгжүүлэхийн тулд урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгаа, нөхөн сэргээх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр тодорхой зорилтууд дэвшүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна.

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот “Хоолны зардлын норматив тогтоох тухай”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Ойн ангийн удирдлага нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна. Мөн тус газраас Шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөрчил арилгах х арга хэмжээ авагдаагүй байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1% хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 67290,8 мянган төгрөгөөс нэг хувиар тооцон 672,9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Ойн ангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10874,1 мянган төгрөгөөр буюу 20 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн данс материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---------------------------------------------------|-------------------|-------------------|---------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | 17,000 | 17,000 |
| Авлага | 1,895,987 | 1,895,335 | (652) |
| Бараа материал | 6,211,420 | 5,787,420 | (424,000) |
| Үндсэн хөрөнгө | 46,234,201 | 35,767,711 | (10,466,490) |
| Нийт хөрөнгө | 54,341,607 | 43,467,466 | (10,874,141) |
| Өр төлбөр | | 1,543 | 1,543 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 54,341,607 | 43,465,924 | (10,875,683) |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 54,341,607 | 43,467,466 | (10,874,141) |

Тайлангийн хугацаанд үндсэн хөрөнгө данс материаллаг дүнгээр өөрчлөгдсөн байна. Энэ нь тайлангийн хугацааны элэгдлийн зардлын дүнгээр буурсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Орлогын тайлангийн үзүүлэлт

Ойн ангийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 26925,6 мянган төгрөгөөр буюу 32,3 хувиар буурсан байна. Нийт орлого буурсан нь тайлант онд ямар нэгэн хөрөнгө оруулалт хийгдээгүйтэй холбоотой юм.

| Үзүүлэлт | өмнөх оны | тайлант оны | Өөрчлөлт |
|-----------------------------------------|------------|-------------|--------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт | 46,820,000 | 53,086,510 | 6,266,510 |
| Төлбөртэй үйлчилгээний орлого | 3,222,790 | 1,491,428 | (1,731,362) |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 33,280,951 | | (33,280,951) |

| | | | |
|-----------------------------|-------------------|-------------------|--------------|
| нэмэлт санхүүжилтийн орлого | | 1,820,200 | 1,820,200 |
| Нийт орлогын дүн | 83,323,741 | 56,398,138 | (26,925,603) |

Өмнөх оны үзүүлэлтээс санхүүжилтийн орлого материаллаг дүнгээр нэмэгдсэн байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 472 тоот тогтоолоор цалин нэмэгдэх шинэчлэл хийгдсэнтэй холбоотойгоор өсчээ.

Төлбөртэй үйлчилгээний орлого 1731,3 мянган төгрөгөөр буурсан нь цаг үеийн нөхцөл байдлын улмаас үйл ажиллагаа хязгаарлагдаж орлого олох боломж муу байснаас шалтгаалжээ.

Тайлант хугацаанд хөрөнгө оруулалт хийгдээгүй тул үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байхгүй байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд үр үрсэлгээ хийх зориулалтаар Аймгийн Засаг даргын 2020 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн А/109 тоот захирамжаар Байгаль хамгаалах сангаас санхүүжүүлэн сум дундын мод үржүүлгийн газарт үр болон мөчир бэлтгэх заралд 1820,2 мянган төгрөг хувиарлагдан ирсэнтэй холбоотой нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Нийт зардлын үзүүлэлт.

| Үзүүлэлт | өмнөх оны | тайлант оны | Өөрчлөлт |
|------------------------------------|-------------------|-------------------|------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Цалин хөлс нэмэгдэл урамшуулал НДШ | 38,572,511 | 47,122,003 | 8,549,491 |
| Хангамж бараа материалын зардал | 8,458,611 | 6,432,190 | (2,026,421) |
| Бусад бараа үйлчилгээний зардал | 14,425,616 | 13,036,620 | (1,388,996) |
| бусад урсгал шилжүүлэг | 585,000 | 700,000 | 115,000 |
| НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 62,041,738 | 67,290,813 | 5,249,074 |

Нийт зардал өмнөх оноос 5249,0 мянган төгрөгөөр буюу 8,4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс цалин хөлс, шимтгэлийн зардал 8549,4, бусад урсгал шилжүүлэг 3300,4 мянган төгрөгөөр буурсан материаллаг өөрчлөлт гарсан байна. Бууралтын шалтгаан нь үйл ажиллагааны хязгаарлалттай холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 59916,5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 59916,5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 59916,5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 59916,5 мянган төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 55916,5 үйл ажиллагааны орлогоос 4000,0 нийт 59916,5 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 53086,5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоор 1491,4, нийт 54577,9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 54577,0 мянган төгрөгийг зарцуулж 0,9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар Аймгийн Засаг даргын 2020 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн А/109 тоот захирамжаар Байгаль хамгаалах сангаас санхүүжүүлэн сум дундын мод үржүүлгийн газарт үр болон мөчир бэлтгэх заралд 1820,2 мянган төгрөг хуваарилагдан ирснийг зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хүрээнд горим сорил хэрэгжүүлээгүй бөгөөд нэгдсэн тайлангийн аудитаар авч үзэхээр шийдвэрлэв.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2630,9 мянган төгрөгийн шатахууныг замын хуудасгүй зарцуулсан алдааг засах зөвлөмж өгсөн нь хэрэгжиж, нярвын тайланг сар бүр гаргах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1326,3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, үйлчилгээний орлого 371,4 мянган төгрөгийн орлого төсвийн гүйцэтгэлийн тайланд дутуу бүртгэгдсэнийг залруулж, 799,2 мянган төгрөгийн алдааг засах зөвлөмж, 155,6 мянган төгрөгийн алдаанд төлбөрийн акт тогтоолоо.

2 ажилтанд үндсэн цалинг илүү тооцож цалин илүү олгосон, 1 хүнд ур чадварын нэмэгдэл олгоогүй, 3 хүнд амралтын цалин илүү тооцож олгосон зэрэгтэй холбоотой 155693 төгрөгийн акт тогтоолоо.

Залруулсан алдаа

Үйл ажиллагааны орлогоос бэлнээр цуглуулсан дүнгээр татварын байгууллагад шилжүүлсэн бөгөөд уг дүнгээр үйлчилгээний орлого дутуу бүртгэгдсэнийг залрууллаа.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 799,2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав. Эдгээр алдааг энэ удаад ковидтой цаг үеийн нөхцөл байдал, иргэдийн сэтгэл санааны таагүй байдлыг харгалзан аудитын материаллагийн дүнд оруулаагүй бөгөөд дараагийн аудитаар дахин давтагдсан нөхцөлд материаллагийн дүн болон дүгнэлтийн төрөл өөрчлөгдөхийг байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтанд анхааруулсан болно.

Шатахуунаас бусад бараа материалын тайлан гаргаж тооцоо бодоогүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүйтэй холбоотой алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД:

Байгууллагын нягтлан бодогчийн сарын цалин 271869 төгрөг байна. Одоогийн мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод түвшин 420,0 мянган төгрөг байгаа тул үндсэн цалинг 420,0 мянган төгрөгөөс дээш дүнгээр олгох асуудлыг анхаарч, төсөвт өөрчлөлт оруулах эсэхийг шийдвэрлэх

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:
Зардлын данстай холбоотой асуудал.

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд шатахуун зарцуулалтын тайлан тооцооноос бусад бараа материалын тайлан эд хариуцагч гаргаагүй, тооцоог бодож актаар баталгаажуулаагүй, зарим бараа материал эд хариуцагчийн тайланд бүртгэгдээгүй байна.

Эрсдэл: Төсвийн болон нягтлан бодох бүртгэлийн хууль, тэдгээрийг хэрэгжүүлэх журам дүрэм зөрчигдөх

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 5.1.2-д заасан иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14,.4.1-д заасан бүх ажил гүйлгээг бүртгэх гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвшөөрч байна.

2.1. Илрүүлэлт: Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу

Эрсдэл: тайлан буруу илэрхийлэгдэх, хуурамч зарлага гаргах

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллах

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Ойн ангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн/ мян.төг/ | Аудитын байгуул- лагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|--------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|-----------------------------------------------------|------------------------------------------------------|-----------------|
| | | | | Нэр | Албан тушаал |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Шатхуунаас бусад бараа материалын тайлан гаргаж тооцоо бодоогүй, нийлэг хальс /6*20 /нярав орлого аваагүй | 799,2 | Зөвлөмж | Дарга | Ц.Даваахүү |
| 2 | Өөрийн орлогыг төсвийн гүйцэтгэлийн тайланд дутуу тооцсон | 371,4 | залруулга | Дарга | Ц.Даваахүү |
| 3 | үндсэн цалин,нэмэгдлийг буруу тооцож илүү олгосон | 89,7 | Акт | Дарга | Ц.Даваахүү |
| 4 | цалин нэмэгдлийг дутуу олгосон | 65,9 | Акт | Дарга | Ц.Даваахүү |
| 5 | НӨАТ-н баримт дутуу | - | Зөвлөмж | Дарга | Ц.Даваахүү |
| | НИЙТ ДҮН | 1,326,3 | | | |

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР